

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төв, Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэгтэй хамтран “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 26 дахь дугаараа бэлтгэн, эрхэм уншигч Та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн энэ дугаарын **“Судалгаа”** хэсэгт Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдлийг макро болон микро түвшинд малчид хэрхэн даван туулж байгаа талаар орон нутгийн ялгаатай нөхцөл байдлаар харьцуулан дүгнэсэн чанарын судалгааны үр дүнг танилцуулж байна. Өсөн нэмэгдсээр байгаа дотоод шилжих хөдөлгөөний боловсролын үйлчилгээний хүртээмжид үзүүлж буй үр нөлөөг Улаанбаатарын жишээгээр тодруулан үр дүн, санал зөвлөмжийг энэ хэсэгт мөн толилуулж байна. Түүнчлэн, хувь хүний орлогын албан татварын орон нутгийн санхүүгийн чадавхид үзүүлэх нөлөөг үнэлсэн судалгааны дүн шинжилгээний үр дүнтэй уншигч та танилцах боломжтой.

“Сургалт” хэсэгт *“Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт, түүнийг хангах арга зам”* сэдвийн хүрээнд хоёрдогч мэдээллийг ашиглан байгууллагын хүний нөөц, түүний үр ашиг болон хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлж буй хүчин зүйлийн шинжилгээ хийх аргачлалыг тодорхой жишээгээр тайлбарласан болно.

“English” хэсгээс Монгол болон Солонгос иргэдийн хоорондын гэрлэлтийн түвшин, динамик өөрчлөлт, хосуудын нийгэм, хүн ам зүйн ялгааг тодорхойлсон судалгааны үр дүн, зөвлөмжийг танилцуулж байна. Монгол дахь хүнсний баталгаат байдал ба ядуурал судалгааны ажлаас ядуу болон ядуу бус хүн амын хүнсний шимт тэжээлийн хэрэглээ ихээхэн ялгаатай байгааг нотолсон статистик сонирхолтой үр дүнтэй танилцаарай. Мөн энэ хэсэгт компанийн нийгмийн хариуцлагын хандлага, Монгол дахь хүрээлэн буй орчны үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, бодлогын зөвлөмжийг толилуулж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт толилуулж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, санал бодлоо хуваалцаж, манай дараагийн дугаарт өөрийн материалаа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Энэ ялдамд, хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, эрдэм шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид болон уг сэтгүүлийн энэ дугаарыг бэлтгэн хэвлэхэд санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх Ухааны Сургуульд, сэтгүүлийн редакцийн хамт олон гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ